



МОНГОЛ УЛС  
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

┌Зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн сул  
орон тоонд сонгон шалгаруулалт зарлах тухай


Шүүхийн захиргааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 18 дугаар зарлигаар батлагдсан “Шүүгчийг сонгон шалгаруулах журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн хавсралтад заасан сул орон тоонд сонгон шалгаруулалт зарласугай.

2.Шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцох нэр дэвшигчийн материал хүлээн авах ажиллагааг 2017 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 09 цаг 00 минутаас 08 дугаар сарын 25-ны өдрийн 17 цаг 00 минут хүртэлх хугацаанд зохион байгуулахыг Шүүхийн мэргэшлийн хорооны Ажлын алба /Н.Мөнхзул/-д үүрэг болгосугай.

3.Нэр дэвшигчээс шалгалт авах, үнэлгээ өгөх ажиллагааг 2017 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 09 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхийг Шүүхийн мэргэшлийн хороонд даалгасугай.

ДАРГА



Н.ЛҮНДЭНДОРЖ

000292

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын  
2017 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн  
69 дугаар тушаалын хавсралт

**Зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн  
сонгон шалгаруулалт зарлах сул орон тоо**

УХА0052 1701517

№	Шүүхийн нэр, албан тушаал	Орон тоо
<b>Улсын дээд шүүхийн шүүгчийн сул орон тоо</b>		
1	Улсын дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхимын шүүгч	1
<b>Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн сул орон тоо</b>		
2	Говьсүмбэр аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
<b>Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн сул орон тоо</b>		
3	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч	1
<b>Анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн сул орон тоо</b>		
4	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
5	Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
6	Говь-Алтай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
7	Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
8	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
9	Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
10	Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
11	Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
12	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1

13	Өвөрхангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
14	Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
15	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч	1
16	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч	1
<b>Анхан шатны шүүхийн шүүгчийн сул орон тоо</b>		
17	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	1
18	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	1
19	Дорнод аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	1
<b>Нийт</b>		<b>19</b>

